

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР  
Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн  
Төсвийн шинжилгээний алба

# МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

/2019 оны 01 дүгээр улирлын гүйцэтгэл/



Улаанбаатар хот  
2019 он


## АГУУЛГА

НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ .....	3
1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн:.....	3-5
1.2. Бодит ДНБ-ий өсөлт ба нэг хүнд ногдох ДНБ: .....	6
ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ .....	7
2.1. Нэгдсэн төсвийн орлого.....	8-10
2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага .....	10-12
2.3. Төсвийн тэнцэл .....	12
ГУРАВ. ГАДААД ХУДАЛДАА .....	12
3.1. Гадаад худалдааны эргэлт: .....	12-14
3.2. Экспорт .....	14-18
3.3. Импорт .....	18-21
ДӨРӨВ. МӨНГӨ, САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ .....	21
4.1. Мөнгөний нийлүүлэлт .....	21-23
4.2. Гадаад валютын албан нөөц .....	23-24
4.3. Төлбөрийн тэнцэл .....	25
ТАВ. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ.....	26
5. Хүн ам, ажил эрхлэлт.....	26
ДҮГНЭЛТ .....	26-28

## НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ

### 1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн:


**2019 оны эхний улирлын байдлаар оны үнээр Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 7.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.0 их наяд төгрөг буюу 15.6 хувиар өссөн байна.**



Монгол Улсын Дотоодын нийт бүтээгдэхүүн<sup>1</sup> нь 2015 оны эхний улиралд 4.6 их наяд, 2016 оны эхний улиралд 4.7 их наяд, 2017 оны эхний улиралд 5.5 их наяд, 2018 оны эхний улиралд 6.4 их наяд төгрөгт хүрсэн бол 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар 7.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.0 их наяд төгрөгөөр буюу 15.6 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан

байна. Нэрлэсэн ДНБ-ий өсөлтөд хөрөнгийн хуримтлал өмнөх оны мөн үеэс 0.7 их наяд төгрөг буюу 31.4 хувиар, эцсийн хэрэглээ мөн 0.5 их наяд төгрөг буюу 10.8 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна. Харин 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар цэвэр экспорт өмнөх оны мөн үеэс 0.2 их наяд төгрөгөөр буурчээ.

**2019 оны эхний улирлын байдлаар 2010 оны зэрэгцүүлэх үнээр ДНБ 3.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.3 их наяд төгрөгөөр нэмэгдэж, эцсийн ашиглалтын аргаар тооцоолсон ДНБ-ий бодит өсөлт 8.6 хувьтай гарсан байна.**



Зэрэгцүүлсэн үнээр тооцсон Дотоодын нийт бүтээгдэхүүн<sup>2</sup> нь 2015 оны 1 дүгээр улиралд 2.9 их наяд, 2016 онд 3.1 их наяд, 2017 онд 3.1 их наяд, 2018 оны мөн үед 3.3 их наяд төгрөг байсан бол 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар 3.6 их наяд төгрөгт хүрч ДНБ-ийн бодит өсөлт 8.6 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

<sup>1</sup> - эцсийн ашиглалтын аргаар оны үнээр тооцоход

<sup>2</sup> - эцсийн ашиглалтын аргаар 2010 оны зэрэгцүүлсэн үнээр тооцоолоход


ДНБ-ий бодит өсөлтөд хөрөнгийн хуримтлал 0.4 их наяд төгрөг буюу 29.5 хувиар, эцсийн хэрэглээ 0.1 их наяд төгрөг буюу 3.8 хувиар өссөн нь нөлөөлж, харин цэвэр экспорт 0.2 их наяд төгрөгөөр буурчээ.

2019 оны эхний улирлын байдлаар ДНБ-ий 78.3 хувийг эцсийн хэрэглээ, 48.9 хувийг хөрөнгийн хуримтлал эзэлж байна.

**Өмнөх оны мөн үетэй харьцуулбал эцсийн ашиглалтын аргаар, оны үнээр тооцсон ДНБ 1.0 их наяд төгрөгөөр нэмэгдэж, үүний дотор эцсийн хэрэглээ 0.5 их наяд төгрөг, хөрөнгийн нийт хуримтлал 0.7 их наяд төгрөгөөр өссөн бол цэвэр экспортын ашиг 0.2 их наяд төгрөгөөр буурсан байна.**

ДНБ-ийг улирлаар харуулбал жил бүрийн эхний улиралд ДНБ-ий хэмжээ харьцангуй бага байснаа хоёрдугаар улирлаас хойш өсдөг зүй тогтол ажиглагдаж байна. 2019 оны эхний улирлын байдлаар ДНБ-ий хэмжээ 7.4 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 1.0 их наяд төгрөгөөр өсч, сүүлийн 5 жилийн дотор хамгийн өндөр үзүүлэлтэд хүрлээ. 2018 оны 1 дүгээр улирлын байдлаар эцсийн хэрэглээ 4.4 их наяд төгрөг байснаа 2019 оны 1 дүгээр улиралд 4.9 их наяд төгрөг, мөн хугацаанд хөрөнгийн хуримтлал 2.2 их наяд төгрөг байсан бол 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар 2.9 их наяд төгрөг болж тус тус өссөн байна. Эцсийн хэрэглээ болон хөрөнгийн хуримтлал нэмэгдсэн нь ДНБ-ий хэмжээ өсөхөд нөлөөлсөн байна.


**График 3. ДНБ, эцсийн ашиглалтын аргаар, оны үнээр, улирлаар /их наяд төгрөг/**



2019 оны 1 дүгээр улиралд цэвэр экспорт -386.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.2 их наяд төгрөгөөр буурсан байна.

**2019 оны 1 дүгээр улирлын байдлаар үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр тооцсон ДНБ 7.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.2 их наяд төгрөгөөр өссөн байна. Үүнд үйлчилгээ 0.6 их наяд, аж үйлдвэр 0.5 их наяд, бүтээгдэхүүний цэвэр татвар 0.1 их наяд, хөдөө аж ахуй 0.02 их наяд төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлжээ.**

**График 4. ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр, улирлаар /их наяд төгрөг/**



2014-2018 оны 1 дүгээр улиралд аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний хэмжээ 1.4-2.8 их наяд төгрөг байсан бол 2019 оны 1 дүгээр улиралд 3.3 их наяд төгрөг, мөн хугацаанд үйлчилгээний салбарын хэмжээ 2.2-3.0 их наяд төгрөг байсан бол, 2019 оны 1 дүгээр улиралд 3.5 их наяд төгрөг болж тус тус өссөн байна. Аж үйлдвэрийн салбарт өсөлт гарсан нь ДНБ-ий хэмжээ нэмэгдэхэд голлон нөлөөлсөн байна.

2019 эхний улирлын байдлаар үйлдвэрлэлийн аргаар, оны үнээрх ДНБ-ийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад үйлчилгээний салбарын үйлдвэрлэл 18.5 хувиар, аж үйлдвэрийн салбар 17.4 хувиар бүтээгдэхүүний цэвэр татварын хэмжээ 12.5 хувиар, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл 7.2 хувиар тус тус өссөн байна.



**2019 оны 1 дүгээр улирлын байдлаар үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ-ий 44.7 хувийг үйлчилгээ, 41.5 хувийг аж үйлдвэр, 10.8 хувийг бүтээгдэхүүний цэвэр татвар, үлдсэн 3.0 хувийг хөдөө аж ахуйн салбар бүрдүүлж байна.**

2010 оны зэрэгцүүлсэн үнээрх ДНБ 18.1 их наяд төгрөгт хүрч, бодит ДНБ-ий 42.3 хувийг үйлчилгээ, 33.8 хувийг аж үйлдвэр, 13.0 хувийг хөдөө аж ахуй, 11.0 хувийг бүтээгдэхүүний цэвэр татвар эзэлж байна.

## 1.2. Бодит ДНБ-ий өсөлт ба нэг хүнд ногдох ДНБ:

**2018 онд ДНБ-ий бодит өсөлт 6.9 хувьд хүрч, нэг хүнд ногдох ДНБ 9,929.3 мянган төгрөг болж өмнөх оноос 13.1 хувь буюу 1,151.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.**

График 6. Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ ба эдийн засгийн өсөлт



2011 онд ДНБ-ий бодит өсөлт 17.3 хувь байх үед нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 4,685.4 мянган төгрөгт хүрч байсан. Харин ДНБ-ий бодит өсөлт 2011 оноос хойш тасралтгүй буурсан ч, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ бага зэргийн өсөлттэй байна.

График 7. Эдийн засгийн өсөлт, улирлаар



Эдийн засгийн өсөлт 2014 оны 3 дугаар улиралд 9.1 хувьд хүрч өссөн ба 2016 оны 3 дугаар улиралд -1.4 хувь хүртэл буурсан. Харин 2016 оны 4 дүгээр улирлаас эхлэн сэргэж, эдийн засгийн бодит өсөлт тогтвортой нэмэгдэж, 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар 8.6 хувьд хүрсэн байна. Гол нэр төрлийн эрдсийн бүтээгдэхүүний зах зээлийн үнэ өссөнөөр экспортын орлого, гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдсэн, улсын төсвийн болон хувийн хэвшлийн салбарын хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаа зэрэг нь нөлөөлжээ.

## ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ

**2019 оны 01 дүгээр улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2,163.4 тэрбум төгрөг, нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 1,969.1 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 194.3 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.**

2019 оны эхний улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 92.3 тэрбум төгрөг буюу 4.5 хувиар давж биелсэн бол төсвийн нийт зарлага 666.6 тэрбум төгрөг буюу 25.3 хувиар төлөвлөсөнөөс дутуу зарцуулагдсан байна.

### Монгол Улсын нэгдсэн төсөв

#### Хүснэгт 1.

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өөрчлөлт (+/-)	
	2019 оны I улирал		Зөрүү	Хувь
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	2,071.1	2,163.4	92.3	4.5%
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,635.7	1,969.1	-666.6	-25.3%
<b>Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл</b>	<b>-564.5</b>	<b>194.3</b>	<b>758.9</b>	<b>-134.4%</b>

Эх сурвалж: Сангийн яам

2019 оны 01 дүгээр улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2,163.4 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 352.6 тэрбум төгрөг буюу 19.5 хувиар нэмэгдэж, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 1,969.1 тэрбум төгрөгт хүрч, 132.5 тэрбум төгрөг буюу 7.2 хувиар өссөн байна.

### Нэгдсэн төсвийн өөрчлөлт, 2015-2018 он

#### Хүснэгт 2.

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2019 оны I улирал				Өөрчлөлт	
					2019.03/2018.03	
	2016	2017	2018	2019	Дүн	Хувь
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	1,095.2	1,504.2	1,810.9	2,163.4	352.6	19.5
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,710.9	1,759.2	1,836.6	1,969.1	132.5	7.2
Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	-615.7	-255.1	-25.8	194.3	220.1	8.5
<b>Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь</b>	<b>-21.0</b>	<b>-8.3</b>	<b>-0.8</b>	<b>5.5</b>	<b>0.0</b>	

Эх сурвалж: Сангийн яам, Үндэсний статистикийн хороо

-дахин их

2019 оны 01 дүгээр улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 194.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 220.1 тэрбум төгрөг буюу 8.5 дахин сайжирсан байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь 5.5 хувь болж, өнгөрсөн оны мөн үеэс 6.3 пунктээр сайжирсан байна.

## 2.1. Нэгдсэн төсвийн орлого

**Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 2,163.4 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 19.5 хувь буюу 352.6 тэрбум төгрөгөөр өсч, тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 4.5 хувь буюу 92.3 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.**

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 91.1 хувийг татварын орлого, 8.9 хувийг татварын бус орлого эзэлж байна.

Нийт тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шатлал бүрээр авч үзвэл Улсын төсөв 1.8 хувь буюу 26.2 тэрбум төгрөгөөр, Нийгмийн даатгалын сангийн төсөв 6.7 хувь буюу 34.7 тэрбум төгрөгөөр, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 12.6 хувь буюу 12.7 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс давж биелсэн бол Орон нутгийн төсөв 3.2 хувь буюу 21.8 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 19.9 хувь буюу 249.4 тэрбум, орон нутгийн төсвийн орлого 2.5 хувь буюу 16.2 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын сангийн орлого 16.9 хувь буюу 79.8 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 64.2 хувь буюу 44.4 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

### **Нэгдсэн төсвийн орлогын 2019 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэл, төсвийн шатлалаар**

#### **Хүснэгт 3.**

Ангилал	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.
<b>Нийт орлого ба тусламжийн дүн</b>	<b>1,798.9</b>	<b>1,774.1</b>	<b>682.2</b>	<b>660.4</b>	<b>517.4</b>	<b>552.1</b>	<b>100.9</b>	<b>113.6</b>
Ирээдүйн өв сан	241.8	255.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тогтворжуулалтын сан	78.8	13.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
<b>Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн</b>	<b>1,478.3</b>	<b>1,504.5</b>	<b>682.2</b>	<b>660.4</b>	<b>517.4</b>	<b>552.1</b>	<b>100.9</b>	<b>113.6</b>
<b>Татварын орлого</b>	<b>1,182.7</b>	<b>1,268.4</b>	<b>277.9</b>	<b>264.1</b>	<b>366.0</b>	<b>400.8</b>	<b>100.9</b>	<b>113.6</b>
Орлогын албан татвар	293.3	342.0	193.1	195.6	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн даатгалын орлого	0.0	0.0	0.0	0.0	366.0	400.8	100.9	113.6
Хөрөнгийн албан татвар	0.0	0.0	40.2	27.8	0.0	0.0	0.0	0.0
Нэмэгдсэн өртгийн албан татвар	367.5	381.6	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Онцгой албан татвар	201.4	213.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тусгай зориулалтын орлого	3.9	4.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Гадаад үйл ажиллагааны орлого	153.9	154.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар, төлбөр, хураамж	162.7	172.9	44.7	40.7	0.0	0.0	0.0	0.0
<b>Татварын бус орлого</b>	<b>295.6</b>	<b>236.0</b>	<b>404.3</b>	<b>396.3</b>	<b>151.4</b>	<b>151.4</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
Нийтлэг татварын бус орлого	158.1	153.1	36.6	33.1	0.0	0.0	0.0	0.0
Хөрөнгийн орлого	0.0	0.0	0.1	0.2	0.0	0.0	0.0	0.0
Тусламжийн орлого	88.0	59.0	2.6	0.2	151.4	151.4	0.0	0.0
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	49.4	24.0	364.9	362.8	0.0	0.0	0.0	0.0


Эх сурвалж: Сангийн яам



**Татварын орлого 1,971.5 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 6.7 хувь буюу 123.6 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.**

Татварын орлогын 27.3 хувийг орлогын албан татвар, 22.3 хувийг нийгмийн даатгалын орлого, 19.4 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 10.8 хувийг онцгой албан татвар, 10.8 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого, 7.8 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 1.4 хувийг хөрөнгийн албан татвар, 0.2 хувийг тусгай зориулалтын орлого бүрдүүлж байна.

**График 8. Татварын орлого /тэрбум төгрөг/**



Төлөвлөгөөтэй харьцуулахад хөрөнгийн албан татвараас бусад бүх төрлийн татварын орлогууд давж биелсэн байна. Үүнд: орлогын албан татвар 10.5 хувь /51.3 тэрбум.төг/, нийгмийн даатгалын орлого 13.4 хувь /51.7 тэрбум.төг/, нэмэгдсэн өртгийн албан татвар 3.8 хувь /14.0 тэрбум.төг/, онцгой албан татвар 6.0 хувь буюу /12.1 тэрбум.төг/, тусгай зориулалтын орлого 5.1 хувь /0.2 тэрбум.төг/, гадаад үйл ажиллагааны орлого 0.3 хувь /0.5 тэрбум.төг/, бусад татвар, төлбөр хураамж 3.0 хувь /6.3 тэрбум.төг/-иар тус тус давж биелсэн байна.

Харин хөрөнгийн албан татвар 30.9 хувь /12.4 тэрбум.төг/-иар төлөвлөснөөс дутуу төвлөрсөн гүйцэтгэлтэй гарчээ.


**Давж биелсэн нийт татварын орлогын өсөлтийн 41.8 хувийг нийгмийн даатгалын орлого, 41.5 хувийг орлогын албан татвар, 11.3 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 9.8 хувийг онцгой албан татвар, 5.1 хувийг бусад татвар, төлбөр хураамжийн орлого, 0.4 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 0.2 хувийг тусгай зориулалтын орлого эзэлсэн бол хөрөнгийн албан татвар 10.0 хувийн бууралттайгаар нөлөөлжээ.**

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2019 оны 01 дүгээр улирлын гүйцэтгэлээр татварын орлого 353.4 тэрбум төгрөг буюу 21.8 хувиар өсөхөд хөрөнгийн албан татвар 3.9 тэрбум (12.4%) төгрөгөөр буурсан ч, орлогын албан татвар 125.3 тэрбум (30.4%), нийгмийн даатгалын орлого 94.6 тэрбум (27.5%), нэмэгдсэн өртгийн албан татвар 0.7 тэрбум (0.2%), онцгой албан татвар 48.9 тэрбум (29.7%), тусгай зориулалтын орлого 1.5 тэрбум (59.1%), гадаад үйл ажиллагааны орлого 29.7 тэрбум (23.8%), бусад татвар, төлбөр, хураамж 56.6 тэрбум (36.1%) төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

**Татварын орлогын өсөлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 35.5 хувийг орлогын албан татвар, 26.8 хувийг нийгмийн даатгалын орлого, 16.0 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого, 13.8 хувийг онцгой албан татвар, 8.4 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 0.4 хувийг тусгай зориулалтын орлого, 0.2 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар эзэлж байна.**

**Татварын бус орлого 191.9 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 0.4 хувь буюу 0.8 тэрбум төгрөгөөр буурсан бол төлөвлөснөөс 31.4 тэрбум төгрөг буюу 14.0 хувиар дутуу төвлөрсөн байна.**

Татварын бус орлого дутуу төвлөрөхөд газрын тосны орлого 6.1 тэрбум, төсөвт байгууллагын өөрийн орлого 4.8 тэрбум төгрөгөөр, мөн тусламжийн орлого 22.9 тэрбум төгрөгөөр тус тус дутуу төвлөрсөн нь голлон нөлөөлжээ. Харин торгуулийн орлого 4.4 тэрбум, хувьцааны ногдол ашиг 0.4 тэрбум, навигацийн орлого 0.2 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс илүү төвлөрчээ.



Татварын бус орлогын 97.0 хувийг нийтлэг татварын бус орлого, 2.9 хувийг тусламжийн орлого, 0.1 хувийг хөрөнгийн орлого эзэлж байна. Нийт татварын бус орлогод эзлэх нийтлэг татварын бус орлогыг бүрдүүлэгч эх үүсвэрүүдийг бүтцийн хувьд авч үзвэл 28.1 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 24.7 хувийг газрын тосны орлого, 20.3 хувийг навигацийн орлого, 9.8 хувийг бусад орлого, 8.6 хувийг торгуулийн орлого, 5.1 хувийг хүүгийн орлого, 0.2 хувийг хувьцааны ногдол ашиг, мөн 0.2 хувийг түрээсийн орлого тус тус эзэлж байна.

## 2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага

**Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 2,635.7 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 74.7 хувийг ашиглаж, 666.6 тэрбум төгрөгийн зардал дутуу зарцуулагдсан байна.**

Тайлант хугацааны төлөвлөгөөтэй харьцуулахад улсын төсвийн зарлага 322.8 тэрбум, орон нутгийн төсвийн зарлага 341.1 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 14.6 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 28.6 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагджээ.

Өмнөх оны мөн үеэс улсын төсвийн нийт зарлага 80.1 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсвийн зарлага 26.4 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зардал 59.3 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зардал 4.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж зарцуулагдсан үзүүлэлттэй байна.

**Нэгдсэн төсвийн нийт зарлагын гүйцэтгэл**

**Хүснэгт 4.**

*/тэрбум төгрөг/*

Үзүүлэлт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Төлөвлөгөөний биелэлт	Өөрчлөлт 2019.I-III/2018.I-III	
	2019.I-III		2018.I-III			Дүн	Хувь
	1	2	3	4			
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,635.7</b>	<b>1,836.6</b>	<b>1,969.1</b>		<b>74.7%</b>	<b>132.5</b>	<b>7.2%</b>
<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	<b>2,783.4</b>	<b>1,830.7</b>	<b>1,968.5</b>		<b>70.7%</b>	<b>137.8</b>	<b>7.5%</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,260.2</b>	<b>1,620.6</b>	<b>1,800.5</b>		<b>79.7%</b>	<b>179.9</b>	<b>11.1%</b>
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,125.4	693.7	826.5		73.4%	132.8	19.1%
ХҮҮ	187.3	230.1	171.1		91.3%	-59.0	-25.6%
ТАТААС	109.5	75.9	52.1		47.6%	-23.8	-31.4%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	838.0	620.9	750.8		89.6%	129.9	20.9%
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>523.2</b>	<b>210.0</b>	<b>168.0</b>		<b>32.1%</b>	<b>-42.1</b>	<b>-20.0%</b>
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>-147.7</b>	<b>5.9</b>	<b>0.6</b>		<b>-0.4%</b>	<b>-5.4</b>	<b>-90.7%</b>

*Эх сурвалж: Сангийн яам*

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл өнгөрсөн оны мөн үеэс 7.2 хувь буюу 132.5 тэрбум төгрөгөөр өсөхөд хөрөнгийн зардал 42.1 тэрбум, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 5.4 тэрбум төгрөгөөр буурсан ч урсгал зардал 179.9 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад урсгал зардлыг бүрдүүлж буй бараа, ажил, үйлчилгээний зардал 19.1 хувь буюу 132.8 тэрбум, урсгал шилжүүлэг 20.9 хувь буюу 129.9 тэрбум төгрөгөөр тус тус өсч, харин зээлийн үйлчилгээний төлбөр 25.6 хувь буюу 59.0 тэрбум төгрөгөөр, татаас 31.4 хувь буюу 23.8 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

**Зээлийн үйлчилгээний төлбөр нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 59.0 тэрбум төгрөг буюу 25.6 хувиар, тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 16.2 тэрбум төгрөгөөр буюу 8.7 хувиар тус тус бага байгаа нь тайлант хугацаанд улсын төсөвт нөлөөлөх хүүгийн зардал буурах төлөвийг харуулж байна.**

Нэгдсэн төсвийн нийт зарлагын 91.4 хувь буюу 1,800.5 тэрбум төгрөгийг урсгал зардал эзэлж байна. Урсгал зардлын 45.9 хувийг бараа, ажил, үйлчилгээний зардал, 41.7 хувийг урсгал шилжүүлэг, 9.5 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 2.9 хувийг татаас эзэлжээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн урсгал зардал 179.9 тэрбум төгрөгөөр өсчээ. Үүнд: зээлийн үйлчилгээний төлбөр 59.0 тэрбум төгрөг, татаас 23.8 тэрбум төгрөгөөр буурсан ч, бараа үйлчилгээний зардал 132.8 тэрбум төгрөг, урсгал шилжүүлэг 129.9 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлжээ.

### 2.3. Төсвийн тэнцэл

2019 оны 1 дүгээр улирлын байдлаар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 194.3 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 5.5 хувьтай тэнцэх хэмжээний ашигтай гарсан байна.

#### Төсвийн тэнцэл

##### Хүснэгт 5.

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Жилийн эцсийн байдлаар			Төлөв	Гүйцэт	Өөрчлөлт(+/-)	
	2016	2017	2018			2019.03/2018.03	дүн
Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	-615.7	-255.1	-25.8	-564.5	194.3	220.1	8.5
Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь	-21.0	-8.3	-0.8	-	5.5	-	-

\*-дахин их

Улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 57.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан ч орон нутгийн төсөв 151.8 тэрбум, нийгмийн даатгалын сангийн төсөв 58.6 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 41.3 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

2019 оны эхний улирлын байдлаар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 19.5 хувиар өсч, харин нийт зарлага 7.2 хувиар нэмэгдсэн нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг өнгөрсөн оны мөн үеэс 220.1 тэрбум төгрөгөөр, төлөвлөсөн хэмжээнээс 758.9 тэрбум төгрөгөөр буурч, эерэг тэнцэл гарахад нөлөөлсөн байна.

2019 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 113.5 тэрбум, Засгийн газрын урт хугацаат дотоод бондын үндсэн төлбөрт 31.2 тэрбум төгрөг төлж, 256.7 тэрбум төгрөгийн гадаад төслийн зээл шинээр авч, мөн 63.5 сая төгрөгийн өмч хувьчлалын орлого төвлөрсөн байна. Шинээр Засгийн газрын урт болон богино хугацаат дотоод, гадаад бонд гаргаагүй байна.

## ГУРАВ. ГАДААД ХУДАЛДАА

### 3.1. Гадаад худалдааны эргэлт:

**2019 оны эхний улирлын байдлаар гадаад худалдааны нийт бараа эргэлт өмнөх оны мөн үеэс 17.0 хувь буюу 444.5 сая ам.доллараар нэмэгдэж, 3,057.4 сая ам.долларт хүрсэн байна.**

Монгол Улс 2019 оны эхний улиралд дэлхийн 120 оронтой гадаад худалдаа хийсэн байна. Экспорт 289.3 сая ам.доллар буюу 19.5 хувиар, импорт 155.3 сая ам.доллар буюу 13.7 хувиар тус тус өссөн байна. Гадаад худалдааны тэнцэл сүүлийн дөрвөн жил дараалан ашигтай гарсан байна.

### Гадаад худалдааны үзүүлэлт

Хүснэгт 6.

/сая ам.доллар/


Үзүүлэлт	3 дугаар сар				Өөрчлөлт	
	2016	2017	2018	2019	Дүн	Хувь
<b>Нийт эргэлтийн бараа</b>	<b>1,558.0</b>	<b>2,076.1</b>	<b>2,612.9</b>	<b>3,057.4</b>	<b>444.5</b>	<b>17.0</b>
- Экспорт	959.0	1,299.9	1,482.4	1,771.7	289.3	19.5
- Импорт	599.1	776.2	1,130.5	1,285.7	155.3	13.7
<b>Тэнцэл</b>	<b>359.9</b>	<b>523.7</b>	<b>351.9</b>	<b>485.9</b>	<b>134.0</b>	<b>38.1</b>

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

**Гадаад худалдааны тэнцэл:** 2019 оны эхний улирлын байдлаар гадаад худалдааны тэнцэл **485.9** сая ам.долларын ашигтай гарсан. Өмнөх оноос **134.0** сая ам.доллар буюу **38.1** хувиар өссөнд экспортын өсөлт нөлөөлсөн байна. Экспортын өсөлтөд чулуу нүүрсний экспорт 132.3 сая ам.доллар, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алтны экспорт 71.6 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

**Экспорт, импортын жилийн өсөлт:** Экспорт болон импортын жилийн өсөлтийн хурдыг 3 сарын гулсах дундаж (2012.01-2019.03)-аар тооцон үзэв. 2012-2016 онд импорт буурсаар ирсэн бөгөөд 2016 оны сүүлчийн хагас жилээс импортын худалдаа эргэн өсч байна. Харин экспортын худалдаа 2017 оны 4 дүгээр улиралд огцом буурч 2018 оны 1 дүгээр улирлын дунд үеэс дахин өсч байна.

График 10. Гадаад худалдааны үзүүлэлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

**Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл:** Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр 529.1 сая ам.долларын ашигтай гарсан ба өнгөрсөн оны мөн үеэс 125.5 сая ам.доллараар өссөн байна.

**Хөрш орнуудтай хийсэн худалдаа:** Гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 61.9 хувь буюу 1,893.0 сая ам.долларын худалдааг БНХАУ-тай, 12.4 хувь буюу 377.9 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийсэн. Үүний дотор БНХАУ нь экспортын 85.8 хувь /1,520.4 сая ам.доллар/, импортын 29.0 хувь /372.6 сая ам.доллар/-ийг эзэлж байгаа бол ОХУ нь экспортын 0.8 хувь /14.9 сая ам.доллар/, импортын 28.2 хувь /363.0 сая ам.доллар/-ийг эзэлж байна. 2019 оны эхний 03 сарын байдлаар гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 74.3 хувь, экспортын 86.6 хувь, импортын 57.2 хувийг хөрш орнууд эзэлж байна.

### Хөрш орнуудын гадаад худалдааны үзүүлэлт

#### Хүснэгт 7.

/сая ам.доллар/

Улс	Төрөл	Жилийн эцсийн гүйцэтгэл				Өөрчлөлт (+/-)	
		Эзлэх хувь	2017 оны эхний 03 сар	2018 оны эхний 03 сар	2019 оны эхний 03 сар	2019/2018	
						Дүн	Хувь
БНХАУ	Нийт эргэлт	61.9	1,436.2	1,661.0	1,893.0	231.9	14.0
	Экспорт	85.8	1,207.7	1,301.7	1,520.4	218.6	16.8
	Импорт	29.0	228.5	359.3	372.6	13.3	3.7
	Тэнцэл		979.2	942.4	1,147.8	205.3	21.8
ОХУ	Нийт эргэлт	12.4	241.0	378.5	377.9	-0.6	-0.2
	Экспорт	0.8	10.8	17.3	14.9	-2.4	-13.8
	Импорт	28.2	230.2	361.3	363.0	1.7	0.5
	Тэнцэл		-219.3	-344.0	-348.1	-4.1	1.2
Бусад	Нийт эргэлт	25.7	399.0	573.3	786.6	213.3	37.2
	Экспорт	13.3	81.4	163.4	236.4	73.0	44.7
	Импорт	42.8	317.6	409.9	550.1	140.2	34.2
	Тэнцэл		-236.2	-246.5	-313.7	-67.2	27.3

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Гол нэр төрлийн эрдсийн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлт нь БНХАУ-тай хийх экспортын худалдааг 16.8 хувь буюу 218.6 сая ам.доллараар нэмэгдүүлэхэд нөлөөлсөн байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нефтийн бүтээгдэхүүний импортын тоо хэмжээ өссөн, үнэ буурсан, суудлын болон ачааны автомашины импортын тоо хэмжээ нэмэгдсэн зэргээс шалтгаалан ОХУ-тай хийсэн импортын худалдаа 1.7 сая ам.доллар буюу 0.5 хувиар, БНХАУ-тай хийсэн импорт 13.3 сая ам.доллар буюу 3.7 хувиар тус тус нэмэгдсэн байна. Монгол Улсын гадаад худалдаа нь 2019 оны эхний улирлын байдлаар БНХАУ-тай ашигтай, харин ОХУ-тай алдагдалтай байна.

### 3.2. Экспорт

**Экспортын худалдаа 2019 оны эхний улирлын гүйцэтгэлээр 1,771.7 сая ам.доллар болж өнгөрсөн оны мөн үеэс 289.3 сая ам.доллар буюу 19.5**

**хувиар нэмэгдсэн байна. Үүнд эрдэс бүтээгдэхүүний экспорт 226.4 сая ам.доллараар өссөн нь нөлөөлжээ.**

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт 1,478.9 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 226.4 сая ам.доллар буюу 18.1 хувиар өссөн бол, эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт 292.7 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 62.9 сая ам.доллар буюу 27.3 хувиар өссөн байна. Нийт экспортын 83.5 хувийг эрдсийн бүтээгдэхүүний экспорт, 16.5 хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт эзэлж байна.

### Эрдсийн бүтээгдэхүүний экспорт


Хүснэгт 8.

/сая ам.доллар/

Үзүүлэлт	Жил бүрийн эхний улирлын байдлаар /сая ам.дол/				Өөрчлөлт		Нийт экспортод эзлэх хувь
	2016	2017	2018	2019	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүн экспорт	733.4	1,159.9	1,252.5	1,478.9	226.4	18.1	83.5
Эрдсээс бусад бүтээгдэхүүн экспорт	225.6	140.0	229.9	292.7	62.9	27.3	16.5
<b>Нийт экспорт</b>	<b>959.0</b>	<b>1,299.9</b>	<b>1,482.4</b>	<b>1,771.7</b>	<b>289.3</b>	<b>19.5</b>	<b>100.0</b>


Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Нийт экспортын орлогын 64.8 хувийг зэсийн баяжмал болон нүүрс гэсэн 2 бүтээгдэхүүний орлого дангаар бүрдүүлж байна.




Зэсийн баяжмал, нүүрс, төмрийн хүдэр болон боловсруулаагүй газрын тосны экспортын өөрчлөлтийг бүтээгдэхүүн бүрээр харууллаа. Үүнд:


**График 11. Зэсийн баяжмалын экспортын өөрчлөлт**



**График 12. Нүүрсний экспортын өөрчлөлт**



**График 13. Төмрийн хүдрийн экспортын өөрчлөлт**





2019 оны эхний улирлын байдлаар зэсийн баяжмал, нүүрс, төмрийн баяжмал, боловсруулаагүй нефть болон алт, цайрын баяжмал зэрэг бүтээгдэхүүн нийт экспортын орлогын 90.4 хувийг эзэлж байна.

**Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт**

**Хүснэгт 9.**

Д/д	Төрөл	Хэмжих нэгж	Жил бүрийн эхний улирлын байдлаар					
			2014	2015	2016	2017	2018	2019
1	Зэсийн баяжмал	мян.тн	214.1	309.4	412.8	365.8	337.7	361.4
		сая ам.дол	349.2	512.2	481.6	380.2	462.5	503.7
2	Нүүрс	сая.тн	3.7	3.2	3.3	8.1	6.8	7.8
		сая ам.дол	206.5	141.3	99.2	541.3	514.5	644.2
3	Төмрийн хүдэр	сая.тн	0.9	1.0	1.0	1.1	1.4	2.1
		сая ам.дол	81.4	58.2	29.1	70.1	63.9	106.5
4	Түүхий газрын тос	сая.баррел	1.6	1.9	2.2	1.8	1.6	1.6
		сая ам.дол	167.6	91.8	73.2	93.1	101.0	87.8
5	Алт	тн	2.2	2.5	2.9	1.1	2.9	4.7
		сая ам.дол	89.8	98.0	111.3	43.7	124.3	195.9
6	Цайрын баяжмал	мян.тн	15.0	28.2	22.8	27.4	32.9	44.0
		сая ам.дол	14.6	35.0	22.5	40.3	60.2	62.6

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2019 эхний улирлын байдлаар эрдсийн бүтээгдэхүүний экспорт өмнөх оны мөн үеэс 226.4 сая ам.доллар буюу 18.1 хувиар өсөхөд дараахь хүчин зүйлс нөлөөлжээ. Үүнд:

- **Нүүрс:** 2019 оны эхний улирлын байдлаар 7.8 сая тонн нүүрс экспортлож 644.2 сая ам.долларын экспортын орлого олжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нүүрсний экспортын орлого 129.7 сая ам.доллараар буюу 25.2 хувиар өссөн байна. Нүүрсний биет хэмжээ 14.7 хувь буюу 1.0 сая тонноор өссөн бөгөөд хилийн дундаж үнэ өмнөх оны мөн үеэс 8.6 хувиар өссөн нь нүүрсний экспортын орлогыг өсөхөд голлон нөлөөлжээ.
- **Зэсийн баяжмал:** 2019 оны эхний улирлын байдлаар зэсийн баяжмалын экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс 8.9 хувь буюу 41.2 сая ам.доллараар нэмэгдэж, 503.7 сая ам.долларт хүрсэн байна. Зэсийн баяжмалын экспортын биет тоо хэмжээ 361.4 мянган тонн болж, өнгөрсөн оны мөн үеэс 7.0 хувь буюу 23.7 мянган тонноор өссөн мөн хилийн дундаж үнэ нь 1.8 хувиар нэмэгдсэн нь экспортын орлого өсөхөд нөлөөлсөн байна.
- **Алт:** 2019 оны эхний улирлын байдлаар 4.7 тонн алт экспортлож, 195.9 сая ам.долларын экспортын орлого олжээ. Алтны экспортын орлого өмнөх оны мөн үеэс 71.6 сая ам.доллараар өссөн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад алтны экспортын тоо хэмжээ 4.7 тонн болж, 62.1 хувиар өссөн ба экспортын дундаж үнэ 0.34 хувиар буурчээ.
- **Төмрийн хүдэр:** 2019 оны эхний улирлын байдлаар төмрийн хүдрийн экспортын тоо хэмжээ 2.1 сая тоннд хүрч, 106.5 сая ам.долларын экспортын

орлого олсон байна. Төмрийн хүдрийн экспортын орлого өмнөх оны мөн үеэс 66.7 хувь буюу 42.6 сая ам.доллараар өсөхөд төмрийн хүдрийн биет хэмжээ 50.0 хувь буюу 0.7 сая тонноор нэмэгдсэн, мөн хилийн үнэ 7.0 ам.доллараар буюу 15.8 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

- **Боловсруулаагүй нефть:** Боловсруулаагүй нефтийн экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс 13.2 сая ам.доллараар буурч, 87.8 сая ам.доллар болсон байна. Боловсруулаагүй нефтийн экспортын тоо хэмжээ өнгөрсөн оны мөн үетэй ижил 1.6 сая баррель хэмжээтэй байгаа ба хилийн дундаж үнэ 54.2 ам.доллар болж, 12.4 хувиар буурсан нь экспортын орлого буурахад нөлөөлжээ.

Нийт экспортын 36.4 хувийг нүүрс, 28.4 хувийг зэсийн баяжмал, 11.1 хувийг алт, 6.0 хувийг төмрийн баяжмал, 5.0 хувийг боловсруулаагүй нефть, 3.5 хувийг цайрын баяжмал, 2.3 хувийг жоншны хүдэр эзэлсэн байна.

### 3.3. Импорт

**2019 оны эхний улирлын байдлаар нийт импортын хэмжээ 1,285.7 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 155.3 сая ам.доллар буюу 13.7 хувиар өссөн байна.**

Эрдсийн бүтээгдэхүүний импорт **315.4 сая** ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс **36.6 сая** ам.доллар буюу **13.1** хувиар, эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт **970.3 сая** ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс **118.7 сая** ам.доллар буюу **13.9** хувиар тус тус өссөн байна.

Нийт импортын **24.5** хувийг нь эрдсийн бүтээгдэхүүний импорт, **75.5** хувийг нь эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт тус тус эзэлж байна.

#### Эрдсийн бүтээгдэхүүний импорт

**Хүснэгт 10.**

Үзүүлэлт	Жил бүрийн эхний улирлын байдлаар /сая ам.долл/				Өмнөх оны мөн үеэс		Нийт импортод эзлэх хувь
	2016	2017	2018	2019	Сая ам.дол	Хувь	
	Эрдсийн бүтээгдэхүүн импорт	129.2	192.0	278.8	315.4	36.6	
Эрдсээс бусад бүтээгдэхүүн импорт	469.9	584.2	851.6	970.3	118.7	13.9	75.5
<b>Нийт импорт</b>	<b>599.1</b>	<b>776.2</b>	<b>1,130.5</b>	<b>1,285.7</b>	<b>155.3</b>	<b>13.7</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2019 оны эхний улирлын байдлаар импортын 40.0 хувийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, 27.0 хувийг хэрэглээний бүтээгдэхүүн, 11.0 хувийг аж үйлдвэрлэлийн орц, 21.0 хувийг нефтийн бүтээгдэхүүн эзэлсэн байна. Хөрөнгө оруулалтын болон нефтийн бүтээгдэхүүний импортод эзлэх хувийн жин өмнөх оны мөн үеэс өссөн үзүүлэлттэй байна.

**Гол нэр төрлийн импортын барааны гүйцэтгэл**  
**Хүснэгт 11.** /сая ам.доллар/

Бүтээгдэхүүн	Эхний улирлын гүйцэтгэл						Өөрчлөлт 2019/2018
	2017		2018		2019		
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь	
<b>Хэрэглээ</b>	<b>254.0</b>	<b>33%</b>	<b>322.0</b>	<b>28%</b>	<b>351.0</b>	<b>27%</b>	<b>29.0</b>
-Түргэн эдэлгээтэй	143	18%	175	15%	170.0	13%	(5.0)
- Удаан эдэлгээтэй	111.0	14%	147.0	13%	181.0	14%	34.0
<b>Хөрөнгө оруулалт</b>	<b>265.0</b>	<b>34%</b>	<b>400.0</b>	<b>35%</b>	<b>519.0</b>	<b>40%</b>	<b>119.0</b>
- Машин, механик тоног төхөрөөмж, эд анги	193.0	25%	256.0	23%	375.0	29%	119.0
- Барилгын материал	45.0	6%	93.0	8%	104.0	8%	11.0
-Хөрөнгө оруулалтын бусад бараа	27.0	3%	51.0	5%	40.0	3%	(11.0)
<b>Аж үйлдвэрлэлийн орц</b>	<b>96.0</b>	<b>12%</b>	<b>176.0</b>	<b>16%</b>	<b>147.0</b>	<b>11%</b>	<b>(29.0)</b>
- Цахилгаан эрчим хүч	24.0	3%	36.0	3%	37.0	3%	1.0
<b>Нефтийн бүтээгдэхүүн</b>	<b>159.0</b>	<b>20%</b>	<b>231.0</b>	<b>20%</b>	<b>267.0</b>	<b>21%</b>	<b>36.0</b>
- Дизель	80.0	10%	134.0	12%	163.0	13%	29.0
- АИ-92, 95	53.0	7%	55.0	5%	69.0	5%	14.0
- А80 ба бусад	26.0	3%	42.0	4%	35.0	3%	(7.0)

Эх сурвалж: Монголбанк

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад импорт нэмэгдэхэд хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн 119.0 сая ам.доллар, хэрэглээний бүтээгдэхүүн 29.0 сая ам.доллар, нефтийн бүтээгдэхүүн 36.0 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлжээ. Тухайлбал машин, механик тоног төхөөрөмж, түүний эд анги 119.0 сая ам.доллар, дизель 29.0 сая ам.доллар, АИ-92, 95 бензин 14.0 сая ам.доллар, удаан эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүн 34.0 сая ам.доллар, барилгын материал 11.0 сая ам.доллараар тус тус нэмэгдсэн байна.

Харин түргэн эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүний импорт 5.0 сая ам.доллар, хөрөнгө оруулалтын бусад барааны импорт 11.0 сая ам.доллар, А80 ба бусад нефтийн бүтээгдэхүүний импорт 7.0 сая ам.доллараар тус тус буурсан байна.

**Хэрэглээний бүтээгдэхүүний импорт** 2018 оны мөн үетэй харьцуулахад 29.0 сая ам.доллараар нэмэгдэхэд удаан эдэлгээтэй бүтээгдэхүүнээс суудлын авто машин, түүний сэлбэг хэрэгслийн импорт 35.0 сая ам.доллараар нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

**Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт** өмнөх оны мөн үеэс 119.0 сая ам.доллараар өсөхөд суудлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги 50.0 сая ам.доллар, машин механик, тоног төхөөрөмж, тэдгээрийн эд анги 68.0 сая ам.доллар, барилгын материал 11.0 сая ам.доллараар тус тус нэмэгдсэн нь нөлөөлжээ.

**Нефтийн бүтээгдэхүүний импорт** нь өмнөх оны мөн үеэс 36.0 сая ам.доллараар өссөн ба дизель түлшний импорт 29.0 сая ам.доллар, АИ-92, АИ-95 бензиний импорт 14.0 сая ам.доллараар өссөн нь нөлөөлжээ.

Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ өмнөх оны мөн үеэс 9 хувиар буурсан ба дээрх бүтээгдэхүүний импортын өсөлт нь тухайн бүтээгдэхүүний импортын тоо хэмжээний өсөлтөөс хамаарсан байна.

**Гол нэр төрлийн бүтээгдэхүүний импортын биет хэмжээ**

**Хүснэгт 12.**

Барааны нэр	Хэмжих нэгж	Жил бүрийн эхний улирлын байдлаар				Өмнөх оны мөн үеэс	
		2016	2017	2018	2019	Дүн	Хувь
Суудлын авто машин	мян.ш	7.5	12.3	11.4	19.7	8.3	72.1
Ачааны автомашин	мян.ш	1.0	1.7	3.9	4.5	0.6	16.6
Дизель түлш	мян.тн	84.3	145.3	206.6	263.4	56.8	27.5
Автобензин	мян.тн	87.2	97.2	86.5	141.8	55.3	63.9
Цахилгаан эрчим хүч	сая.квт.ц	353.1	260.5	386.6	436.6	50.0	12.9
Согтууруулах ундаа	сая.л	2.3	1.0	2.0	0.9	(1.1)	(56.2)
Шар айраг	сая.л	2.1	0.9	1.7	0.5	(1.2)	(70.1)
Янжуур	сая.ш	510.4	611.8	416.7	557.6	140.9	33.8
Цагаан будаа	мян.тн	3.8	3.9	8.4	5.9	(2.6)	(30.5)
Улаан буудай	мян.тн	70.3	-	110.6	-	(110.6)	(100.0)
Элсэн чихэр	мян.тн	9.5	10.8	16.0	11.2	(4.8)	(29.9)
Гахайн мах, өөх	мян.тн	0.6	1.2	2.1	0.5	(1.7)	(77.8)
Шинэ дугуй	мян.ш	26.9	26.4	25.2	47.6	22.4	88.9
Бульдозер, авто хусуур, индүүдэгч, тэгшлэгч, экскаватор	ш	34.0	75.0	228.0	271.0	43.0	18.9
Компьютер, түүний бүрдэл хэсэг	мян.ш	15.0	11.1	19.0	18.7	(0.3)	(1.6)
Тээврийн хэрэгслийн сэлбэг, эд анги	мян.ш	69.6	145.1	142.5	184.8	42.3	29.7

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

**Гол нэр төрлийн бүтээгдэхүүний импортын дүн**

**Хүснэгт 13.**

/сая ам.доллар/

Барааны төрөл	Жил бүрийн эхний улирлын байдлаар				Өмнөх оны мөн үеэс	
	2016	2017	2018	2019	Дүн	Хувь
Суудлын авто машин	43.2	55.4	73.4	105.9	32.5	44.2
Ачааны автомашин	8.8	19.6	53.5	51.8	(1.7)	(3.2)
Дизель түлш	35.2	79.6	133.8	163.0	29.2	21.8
Автобензин	40.3	59.2	58.7	77.4	18.6	31.7
Цахилгаан эрчим хүч	32.1	23.9	36.1	37.5	1.4	3.8
Согтууруулах ундаа	1.9	1.2	2.7	3.6	0.9	33.2
Шар айраг	0.7	0.5	0.8	0.4	(0.4)	(46.5)
Янжуур	11.9	14.2	8.8	11.2	2.4	27.6
Цагаан будаа	2.5	2.2	5.2	3.2	(1.9)	(37.4)
Улаан буудай	13.5	-	21.8	-	(21.8)	(100.0)

Элсэн чихэр	4.4	5.5	7.7	5.0	(2.7)	(35.0)
Гахайн мах, өөх	0.9	2.0	2.7	0.9	(1.9)	(68.2)
Шинэ дугуй	6.2	9.8	11.3	15.2	3.9	34.8
Бульдозер, авто хусуур, индүүдэгч, тэгшлэгч, экскаватор	2.8	7.0	18.5	54.3	35.7	192.8
Компьютер, түүний бүрдэл хэсэг	8.4	3.9	7.2	9.0	1.8	24.6
Тээврийн хэрэгслийн сэлбэг, эд анги	2.4	3.8	6.4	8.3	1.9	30.1
<b>Нийт импортод эзлэх хувь</b>	<b>12.2</b>	<b>12.8</b>	<b>11.9</b>	<b>16.2</b>		

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

## ДӨРӨВ. МӨНГӨ, САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

### 4.1. Мөнгөний нийлүүлэлт

**Мөнгөний нийлүүлэлт 2019 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр 19,699.6 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 3,625.7 тэрбум төгрөг буюу 22.6 хувиар өссөн байна.**

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад мөнгөний нийлүүлэлт нэмэгдэхэд бараг мөнгө 2,735.7 тэрбум төгрөг буюу 20.6 хувиар өссөн нь нөлөөлжээ. Төгрөгийн хадгаламж 2,288.3 тэрбум төгрөг буюу 25.8 хувь, валютын хадгаламж 383.7 тэрбум төгрөг буюу 15.3 хувь, валютын харилцах 63.7 тэрбум төгрөг буюу 3.3 хувиар тус тус өссөн байна.

### Мөнгөний нийлүүлэлтийн үзүүлэлтүүд

#### Хүснэгт 14.

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2019 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэл				Өөрчлөлт (+/-)	
					2019/2018	
	2016	2017	2018	2019	Дүн	Хувь
<b>Мөнгөний нийлүүлэлт (M2)</b>	<b>10,112.4</b>	<b>12,259.3</b>	<b>16,073.9</b>	<b>19,699.6</b>	<b>3,625.7</b>	<b>22.6</b>
<b>Бараг мөнгө</b>	<b>8,528.7</b>	<b>10,134.4</b>	<b>13,297.3</b>	<b>16,032.9</b>	<b>2,735.7</b>	<b>20.6</b>
- Төгрөгийн хадгаламж	5,467.3	6,464.3	8,859.4	11,147.8	2,288.3	25.8
- Валютын хадгаламж	2,103.6	2,347.4	2,513.2	2,896.8	383.7	15.3
- Валютын харилцах	957.7	1,322.8	1,924.6	1,988.3	63.7	3.3
<b>M1 мөнгө</b>	<b>1,583.7</b>	<b>2,124.9</b>	<b>2,776.7</b>	<b>3,666.6</b>	<b>890.0</b>	<b>32.1</b>
<b>Гүйлгээнд гарсан бэлэн мөнгө</b>	<b>658.6</b>	<b>788.3</b>	<b>840.4</b>	<b>897.8</b>	<b>57.4</b>	<b>6.8</b>

Эх сурвалж: Монголбанк

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр 17.5 их наяд төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 3.3 их наяд төгрөг буюу 23.5 хувиар нэмэгдсэн байна.

### Зээлийн өрийн үлдэгдэл

#### Хүснэгт 15.

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2019 он 1 дүгээр улирлын гүйцэтгэл				Өөрчлөлт (+/-)	
					2019.03/2018.03	
	2016	2017	2018	2019	Дүн	Хувь
<b>Зээлийн өрийн үлдэгдэл</b>	<b>11,835.5</b>	<b>12,678.5</b>	<b>14,139.5</b>	<b>17,461.9</b>	<b>3,322.4</b>	<b>23.5</b>
- Хэвийн зээл	9,902.5	10,647.9	11,971.8	14,683.0	2,711.2	22.6

- Хугацаа хэтэрсэн зээл	965.1	995.1	935.9	913.7	-22.2	(2.4)
- Чанаргүй зээл	967.9	1,035.5	1,231.8	1,865.2	633.4	51.4
Чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх %	8.2	8.2	8.7	10.7	2.0	22.6
Хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх %	8.2	7.8	6.6	5.2	-1.4	(20.9)

Эх сурвалж: Монголбанк

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр 913.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 22.2 тэрбум төгрөг буюу 2.4 хувиар буурсан байна. Хугацаа хэтэрсэн зээл нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 5.2 хувь, хэвийн зээлийн 6.2 хувийг тус тус эзэлжээ.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2019 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр 1,865.2 тэрбум төгрөгт хүрсэн байна. Чанаргүй зээл нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 10.7 хувь, хэвийн зээлийн 12.7 хувийг эзэлсэн байна. Зээлийн эргэн төлөлт удааширсан, хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл нэмэгдэж байгаа нь банкны тогтолцооны хувьд ихээхэн эрсдлийг бий болгохоор байна.


Нийт чанаргүй зээлийн 84.8 хувийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн зээл, 14.6 хувийг иргэдийн зээл тус тус эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үеэс чанаргүй зээл 633.4 тэрбум төгрөг буюу 51.4 хувиар өссөн бөгөөд энэ өсөлтийн 92.0 хувь буюу 582.3 тэрбум төгрөгийг аж ахуйн нэгж, 8.0 хувь буюу 50.6 тэрбум төгрөгийг иргэдийн зээл эзэлсэн байна.

**Үнэт цаас:** Үнэт цаасны арилжаагаар 2019 оны эхний улирлын байдлаар нийт **187.5 сая** ширхэг үнэт цаас арилжаалагдаж, **67.5** тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс **24.4 тэрбум** төгрөг буюу **56.7** хувиар өссөн байна.

Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 2019 оны эхний улирлын байдлаар **23.1 тэрбум** төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс **9.2** хувиар буюу **2.3** тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2019 оны эхний улирлын байдлаар **20,899.7** болж, өмнөх оны мөн үеэс **10.3** нэгж буюу **0.05** хувиар буурсан байна.

**Валютын ханш:** 2019 оны эхний улирлын гүйцэтгэлээр Монгол банкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 2,632.51 төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 9.9 хувиар суларч, оны эхнээс 0.6 хувиар чангарсан байна. Мөн төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 392.31 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.5 хувиар, оны эхнээс 0.5 хувиар тус тус суларсан байна.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

**Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдсэн улсын инфляци:** Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдсэн улсын инфляци 2019 оны эхний улирлын байдлаар 6.7 хувь болж, өмнөх сараас 0.2 пунктээр буурсан байгаа ба өмнөх оны мөн үеэс 0.1 пунктээр өссөн байна. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 3 дугаар сард 6.7 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 8.2 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 4.1 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 4.9 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 8.7 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 9.9 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.



Эх сурвалж: Монголбанк

#### 4.2. Гадаад валютын албан нөөц

Нийт албан нөөцийн хэмжээ 2019 оны эхний улирлын байдлаар 3,660.4 сая ам.долларт хүрээд байна. Гадаад валютын албан нөөц өмнөх оны мөн үеэс 677.3 сая ам.доллар буюу 1.2 дахин нэмэгдсэн байна.



Эх сурвалж: Монголбанк, Үндэсний статистикийн хороо

Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2019 оны эхний улирлын байдлаар 3,660.4 сая ам.доллар буюу 3 сарын дундажаар тооцсон импортын 8.5 сарын хэрэгцээг хангах түвшинд байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад импортын хэмжээ өссөн, мөн гадаад валютын албан нөөц өссөн нь импортын сарын хэрэгцээг хангах түвшинг нэмэгдүүлжээ.


**Гадаад валютын албан нөөц ба импорт**

**Хүснэгт 16.**

Д/д	Үзүүлэлт	2014.03	2015.03	2016.03	2017.03	2018.03	2019.03
1	Нийт импорт	996.0	701.7	599.1	776.2	1,130.5	1,285.7
2	Гадаад валютын нийт нөөц	1,943.3	1,323.9	1,265.3	1,109.2	2,983.1	3,660.4
3	Импортын хэрэгцээг хангах түвшин /сар/	5.9	5.7	6.3	4.3	7.9	8.5

Эх сурвалж: Монголбанк, Үндэсний статистикийн хороо

Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ 2019 оны эхний улирлын байдлаар 784.6 кг болж, өмнөх оны мөн үеэс 1,517.2 кг-аар буурсан байна.



Эх сурвалж: Монголбанк



### 4.3. Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцэл нь урсгал болон хөрөнгийн дансны тэнцэл ба санхүүгийн тэнцлээс бүрддэг. 2019 оны эхний улирлын байдлаар урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 373.2 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн тэнцэл 530.1 сая ам.долларын ашигтай гарснаар төлбөрийн тэнцэл 219.6 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 261.8 сая ам.доллараар өсч, төлбөрийн тэнцэл сайжирсан байна.

2019 оны эхний улирлын байдлаар урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 373.2 сая ам.долларын алдагдалтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 52.7 сая ам.доллараар өсч, төлбөрийн тэнцэл сайжирсан байна.

2019 оны эхний улирлын байдлаар урсгал данс 393.0 сая ам.доллар, үүний дотор цэвэр урсгал шилжүүлэг 76.4 сая ам.доллар гарсан бол харин бараа ба үйлчилгээ 172.0 сая ам.долларын, цэвэр орлого 297.4 сая ам.долларын алдагдалтай гарсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад урсгал дансны алдагдал 47.9 сая ам.доллараар буурсан байна.

Урсгал дансны алдагдалд бараа, үйлчилгээний худалдааны тэнцлийн алдагдал 135.9 сая ам.доллараар буурсан нь нөлөөлжээ.

2019 оны 1 дүгээр улирлын байдлаар санхүүгийн дансны тэнцэл 530.1 сая ам.долларын ашигтай гарсан нь өмнөх оны мөн үеэс 232.6 сая ам.доллараар өссөн байна.

Төлбөрийн тэнцэл 219.6 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 261.8 сая ам.доллараар ашгийн хэмжээ өссөн байна.

#### Төлбөрийн тэнцэл, 2017.03 – 2019.03

##### Хүснэгт 17.

Үзүүлэлт	Гүйцэтгэл			/сая ам.доллар/ 1 дүгээр улирлын өөрчлөлт (+/-)	
	2017.I-III	2018.I-III	2019.I-III	2018/2017	2019/2018
<b>I. Урсгал данс</b>	<b>-148.1</b>	<b>-440.9</b>	<b>-393.0</b>	<b>-292.8</b>	<b>47.9</b>
А. Бараа ба үйлчилгээний худалдаа	91.8	-308.0	-172.0	-399.8	135.9
В. Орлого	-280.1	-212.9	-297.4	67.1	-84.5
С. Урсгал шилжүүлэг (цэвэр)	40.1	80.0	76.4	39.8	-3.5
<b>II. Хөрөнгийн данс</b>	<b>18.4</b>	<b>15.0</b>	<b>19.8</b>	<b>-3.4</b>	<b>4.8</b>
1. Урсгал болон Хөрөнгийн дансны тэнцэл (зээлдүүлэг + / зээллэг -)	-129.7	-425.9	-373.2	-296.1	52.7
<b>III. Санхүүгийн данс</b>	<b>-120.4</b>	<b>-297.5</b>	<b>-530.1</b>	<b>-177.1</b>	<b>-232.6</b>
2. Санхүүгийн дансны тэнцэл	-120.4	-297.5	-530.1	-177.1	-232.6
<b>IV. Алдаа болон орхигдуулга</b>	<b>-154.4</b>	<b>86.2</b>	<b>62.7</b>	<b>240.5</b>	<b>-23.5</b>
3. Төлбөрийн тэнцлийн нийт дүн	-163.7	-42.2	219.6	121.5	261.8

Эх сурвалж: Монголбанкны 5 сарын мэдээлэл

## ТАВ. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

### 5. Хүн ам, ажил эрхлэлт

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн иргэд 2019 оны эхний улирлын байдлаар 31.8 мянган хүн болж, үүнээс 21.7 мянга нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 10.1 мянга нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 5.9 хувь буюу 1375 хүнээр буурсан байна.

Энэ оны эхний улирлын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэдийн 47.9 хувийг бүрэн дунд, 30.0 хувийг дипломын болон бакалаврын дээд, 7.1 хувийг техникийн болон мэргэжлийн, 5.7 хувийг суурь, 4.7 хувийг тусгай мэргэжлийн дунд, 2.3 хувийг бага, 1.1 хувийг магистр, доктор, 1.2 хувийг боловсролгүй иргэд эзэлж байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 52.1 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

### ДҮГНЭЛТ

#### 1. Эдийн засагт гарч буй нааштай өөрчлөлтүүд

- **Эдийн засагт бодит өсөлт гарч байна.** Эдийн засгийн бодит өсөлт 2018 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 6.9 хувьд хүрч байсан бол 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар 8.6 хувьд хүрсэн байна. Энэхүү өсөлтөд аж үйлдвэр, барилгын салбар болон үйлчилгээний салбарын өсөлт нөлөөлсөн байна. Нөгөө талдаа эцсийн хэрэглээ болон хөрөнгийн хуримтлалд өсөлт гарсан нь нөлөөлжээ.
- **Төсвийн орлого нэмэгдэж байна.** Өмнөх жилүүдэд буюу 2017 оны 1 дүгээр улиралд **1.5 их наяд** төгрөг байсан нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2018 оны мөн үед **1.8 их наяд** болж өссөн бол 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар **2.2 их наяд** төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс **352.6 тэрбум** төгрөг буюу 19.5 хувиар, төлөвлөгөөнөөс **92.3 тэрбум** төгрөгөөр буюу **4.5** хувиар тус тус нэмэгдсэн байна. Улсын төсөв, нийгмийн даатгалын сангийн болон эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн орлого тус тус давж биелсэн үзүүлэлттэй байна.
- **Төсвийн орлогын өсөлт, зарлагын хэмнэлтийн нөлөөллөөр нэгдсэн төсвийн тэнцлийн алдагдал буурч, тэнцэл сайжирч, ашигтай гарсан байна.** 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар төсвийн тэнцлийн алдагдлын ДНБ-нд эзлэх хувь 5.5 хувьтай гарч, өмнөх оны мөн үеэс 6.3 пунктээр буурч, төсвийн тэнцэл сайжирлаа.
- **Гадаад худалдааны үзүүлэлтүүд сайжирч, экспорт болон импортын худалдаа нэмэгдэж, гадаад худалдаа ашигтай үзүүлэлттэй гарчээ.** 2019 оны эхний улирлын байдлаар экспорт 1.8 тэрбум ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 289.3 сая ам.доллар буюу 17.0 хувиар, импорт 1.3 тэрбум ам.долларт хүрч, 155.3 сая ам.доллар буюу 13.7 хувиар тус тус өслөө. Гадаад худалдааны тэнцэл 485.9 сая ам.долларын ашигтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 134.0 сая ам.доллар буюу 38.1 хувиар сайжирсан байна.

Экспортын өсөлтөд эрдэс бүтээгдэхүүний экспорт, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс хэсэгт багтах барааны экспорт, нэхмэлийн материал болон нэхмэл эдлэлийн экспорт өссөн нь голлон нөлөөлжээ.

Импортын өсөлтөд эрдэс бүтээгдэхүүний импорт, машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэгийн импорт, үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүний импорт, авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд ангийн импортийн өсөлт голлон нөлөөлсөн байна.

- **Мөнгөний нийлүүлэлт өслөө.** Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 56.6 хувийг нь төгрөгийн хадгаламж, 24.8 хувийг нь валютын хадгаламж, харилцахын өсөлт эзэлж байна.
- **Гадаад валютын албан нөөц тогтвортой өсч, импортын хэрэгцээг хангах түвшин нэмэгдэж байна.** Гадаад валютын албан нөөц өмнөх жилүүдэд тасралтгүй буурч 2016 оны 9 сард 1,092.4 сая ам.долларт хүрсэн хэдий ч 2017 оны эхний улирлаас хойш эргэн өсч 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар 3,660.4 сая ам.доллар болсон байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад гадаад валютын албан нөөц 322.7 сая ам.доллараар өссөн байна.
- **Хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагаа идэвхжсэн байна.** Үнэт цаасны арилжаагаар 2019 оны эхний улирлын байдлаар нийт **187.5 сая** ширхэг үнэт цаас арилжаалагдаж, **67.5** тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс **56.7** хувиар өссөн байна.
- **Зээлийн үйлчилгээний төлбөр буурсан байна.** Нэгдсэн төсвийн зээлийн үйлчилгээний төлбөр 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар 171.1 тэрбум төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 7.9 хувь, нийт зарлагын 8.7 хувийг эзэлж байна. 2015 оны мөн үетэй харьцуулахад зээлийн үйлчилгээний төлбөр 2018 оны 1 дүгээр улирлын байдлаар 3.6 дахин өссөн байна. Харин 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар 2018 оны мөн үетэй харьцуулахад 59.3 тэрбум төгрөгөөр буюу 25.7 хувиар буурсан байна. Зээлийн үйлчилгээний төлбөр тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 16.2 тэрбум төгрөгөөр бага байгаа нь улсын төсөвт нөлөөлөх хүүгийн зардал буурах төлөвийг харуулж байна.



- **Төлбөрийн тэнцэл ашигтай гарлаа.** Төлбөрийн тэнцэл 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар 219.0 сая ам.долларын ашигтай гарлаа. Үүнд урсгал ба хөрөнгийн данс 2019 оны 1 дүгээр улиралд 277.4 сая ам.долларын алдагдалтай,

санхүүгийн данс 318.5 сая ам.долларын ашигтай гарснаар нийт төлбөрийн тэнцэл 219.0 сая ам.долларын ашигтай гарсан. Статистикийн алдаа ба орхигдуулгын дүн 178.0 сая ам.доллар байна.

## **2. Нийгэм, эдийн засагт тулгамдаж буй зарим асуудал**

- **Валютын ханш чангарсан байна.** 2019 оны эхний улирлын байдлаар төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш нь 2,632.51 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 9.9 хувиар суларсан бол төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн ханш 383.0 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.5 хувиар, оны эхнээс 0.5 хувиар тус тус суларсан байна.
- **Чанаргүй зээлийн хэмжээ өссөн байна.** 2019 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр чанаргүй зээл 633.4 тэрбум төгрөгөөр өсч 1,865.2 тэрбум төгрөгт хүрлээ. Чанаргүй зээл нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 10.7 хувийг эзэлж, эрсдэл өндөр хэвээр байна. Чанаргүй зээлийн 84.8 хувийг хувийн хэвшил, 8.0 хувийг иргэдийн зээл эзэлсэн байна.
- **Хөрш орны эдийн засгаас хамааралтай, түүхий эдэд суурилсан экспортын бүтэцтэй хэвээр байна.** Нийт экспортын 83.5 хувийг эрдсийн бүтээгдэхүүний экспорт эзэлж байна. Гадаад орчны тодорхой бус хүчин зүйлүүд нь экспортын түүхий эдийн үнэ эрэлтэд нөлөөлөх эрсдэл байна. Нийт гадаад худалдааны эргэлтэд хөрш орнууд дийлэнх хувийг эзэлж байгаа боловч нийт экспортын 0.8 хувийг ОХУ-ын экспорт эзэлж байгааг цаашид нэмэгдүүлэх боломжуудыг судлах хэрэгтэй юм. Мөн эдийн засаг, түүний дотор экспортын бүтээгдэхүүний төрөлжилтөд анхаарах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

---оОо---

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН  
МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН  
ТӨСВИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБА